ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Хархорин сумын Ерөнхий Боловсролын Орхон сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/105/НА-СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Б.Алтанцэцэг

Утас: 99016193 Цахим хаяг:altaa_6116@yahoo.com


Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .......... 2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... 3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 11
3. Аудитын тайлан .......... 12
3.1 Ерөнхий зүйл .......... 12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .......... 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......... 13
3.4 Материаллаг байдал .......... 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .......... 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .......... 14
3.8 Аудитын гол асуудал .......... 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .......... 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 15
4. Аудитын илрүүлэлт .......... 15
4.1 Залруулсан алдаа .......... 15
4.2 Төлбөрийн акт .......... 16
4.3 Албан шаардлага .......... 16
4.4 Зөвлөмж .......... 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .......... 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг
Утас/Факс: (076) 7032 3253
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

ХАРХОРИН СУМЫН 1-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.ЭНХТУЯА ТАНАА

2022.02.18 № 122

танай ____________-ны № ____________-т

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Хархорин сумын 1-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хархорин сумын 1-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

# Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| Данс код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **86,813,672.83** | **90,365,133.88** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | | |
| 33 | **АВЛАГА** | **8,612,598.83** | **90,362.77** |
| 33500 | Бусад авлага | 8,612,598.83 | 90,362.77 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 8,612,598.83 | 90,362.77 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | | |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **78,201,074.00** | **90,274,771.11** |
| 35100 | Түүхий эд материал | 56,769,416.00 | 64,354,763.11 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 55,958,716.00 | 63,109,163.11 |
| 35130 | Эм боох материал | 810,700.00 | 1,245,600.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | 21,431,658.00 | 25,920,008.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,799,800.00 | 5,799,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,467,550.00 | 1,284,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,568,220.00 | 3,494,020.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,334,600.00 | 7,080,700.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,261,488.00 | 8,261,488.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,326,282,649.65** | **4,516,446,273.74** |
| **371** | **Урт хугацаат хадгаламж** | - | - |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,326,282,649.65** | **4,516,446,273.74** |
| 391 | Газар | | |
| **39200** | **Биет хөрөнгө** | **2,721,132,349.65** | **3,726,169,355.98** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,654,621,727.09 | 3,900,513,937.51 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (183,525,075.67) | (378,775,968.39) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 19,625,000.00 | 19,625,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,090,277.76) | (4,361,111.04) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 215,605,067.27 | 205,261,404.91 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (86,998,681.57) | (95,750,438.43) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 196,767,690.72 | 196,662,001.14 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл -Тавилга | (93,873,100.43) | (117,005,469.72) |
| 39217 | Номын фонд | 6,706,300.00 | 10,658,917.76 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 598,444,000.00 | 779,618,000.00 |
| 39301 | Програм хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (400,000.00) | (400,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 598,444,000.00 | 779,618,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,413,096,322.48** | **4,606,811,407.62** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **71963.00** | **0.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 71963.00 | 0.00 |
| | | | 0.00 |
| 411 | **Богино хугацаат үнэт цаас** | 0.00 | 0.00 |
| 4112 | **Гадаад валют** | 0.00 | |
| 413 | **Өглөг** | 71963.00 | 0.00 |
| 4136 | **Бусад өглөг** | 71963.00 | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 71963.00 | 0.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,413,024,359.48** | **4,606,811,407.62** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **3,413,024,359.48** | **4,606,811,407.62** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,321,740,205.00 | 1,321,740,205.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 973,199,950.43 | 2,166,986,998.57 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 948,407,873.64 | 973,199,950.43 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 24,792,076.79 | 1,193,787,048.14 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,118,084,204.05 | 1,118,084,204.05 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,413,096,322.48** | **4,606,811,407.62** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**төгрөгөөр**

| Данс код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,874,169,865.62** | **3,103,833,128.01** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,853,369,365.62** | **1,353,221,420.01** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 158,520,065.62 | 1,353,221,420.01 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 146,987,470.62 | 1,350,614,912.90 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 11,532,595.00 | 2,606,507.11 |
| 1220 | ТУСЛАМЖИЙН ОРЛОГО | 182,856,700.00 | - |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 182,856,700.00 | - |
| 1230 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 1,511,992,600.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,511,992,600.00 | - |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **20,800,500.00** | **1,750,611,708.00** |
| 1310 | Улсын төсвөөс | - | 1,503,074,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 1,503,074,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 20,800,500.00 | 9,013,408.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 1,853,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 6,505,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 8,600,000.00 | 7,159,508.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,695,500.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 238,523,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 238,523,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **1,849,377,788.83** | **1,910,046,079.87** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,849,377,788.83** | **1,910,046,079.87** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,809,155,441.93 | 1,850,440,363.83 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,251,149,442.00 | 1,184,609,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 840,696,315.00 | 736,523,655.00 |
| 210102 | Нэмэгдэл | 317,649,601.00 | 378,073,249.00 |
| 210104 | Урамшуулал | 92,803,526.00 | 70,012,696.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 159,002,082.22 | 156,644,530.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 109,800,748.96 | 109,007,894.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,342,329.54 | 12,105,191.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,873,683.63 | 9,616,952.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,449,305.61 | 2,350,887.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,536,014.48 | 23,563,603.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 168,766,666.05 | 229,518,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,816,441.05 | 10,695,052.00 |
| 210302 | Түлш, халаалт | 141,783,615.00 | 201,672,140.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,166,610.00 | 17,150,908.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,747,884.00 | 11,874,015.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,120,184.00 | 4,396,106.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,899,350.00 | 2,956,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 995,000.00 | 770,950.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 5,600.00 | 244,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 778,700.00 | 800,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,949,050.00 | 2,705,359.00 |
| 2105 | Нормативт зардал | 40,005,080.00 | 67,685,890.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,450,900.00 | 1,595,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 37,241,080.00 | 66,010,490.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 313,100.00 | 80,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,700,880.00 | 11,109,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,700,880.00 | 11,109,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,155,400.00 | 1,289,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,155,400.00 | 1,289,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,628,000.00 | 5,817,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,628,000.00 | 5,241,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 576,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 163,000,007.66 | 181,891,628.81 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,554,600.00 | 1,511,300.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,675,866.00 | 1,050,940.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 159,769,541.66 | 179,329,388.81 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 40,222,346.90 | 59,605,716.04 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 16,210,286.90 | 7,565,106.04 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,210,286.90 | 7,565,106.04 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 24,012,060.00 | 52,040,610.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,692,060.00 | 51,440,610.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,320,000.00 | 600,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **24,792,076.79** | **1,193,787,048.14** |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | - |
| 6 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **24,792,076.79** | **1,193,787,048.14** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|---|
| 1 | ҮЛДЭГДЭЛ | 1,321,740,205.00 | 1,118,084,204.05 | 973,199,950.43 | 3,413,024,359.48 |
| 8 | ҮЛДЭГДЭЛ | 1,321,740,205.00 | 1,118,084,204.05 | 973,199,950.43 | 3,413,024,359.48 |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 10 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,321,740,205.00 | 1,118,084,204.05 | 973,199,950.43 | 3,413,024,359.48 |
| 15 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,193,787,048.14 | 1,193,787,048.14 |
| 16 | ҮЛДЭГДЭЛ | 1,321,740,205.00 | 1,118,084,204.05 | 2,166,986,998.57 | 4,606,811,407.62 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

| Данс код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,715,649,800.00** | **1,750,611,708.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,694,849,300.00** | **-** |
| 1220 | ТУСЛАМЖИЙН ОРЛОГО | 182,856,700.00 | - |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 182,856,700.00 | - |
| 1230 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 1,511,992,600.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,511,992,600.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **20,800,500.00** | **1,750,611,708.00** |
| 1310 | Улсын төсвөөс | - | 1,503,074,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 1,503,074,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 20,800,500.00 | 9,013,408.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 1,853,900.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 6,505,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 8,600,000.00 | 7,159,508.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,695,500.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 238,523,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 238,523,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **1,706,988,800.00** | **1,740,333,608.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,706,988,800.00** | **1,740,333,608.00** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,667,033,253.10 | 1,677,902,001.96 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,251,149,442.00 | 1,184,609,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 840,696,315.00 | 736,523,655.00 |
| 210102 | Нэмэгдэл | 317,649,601.00 | 378,073,249.00 |
| 210104 | Урамшуулал | 92,803,526.00 | 70,012,696.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 158,690,965.05 | 156,722,293.96 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 109,489,631.79 | 109,085,658.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,342,329.54 | 12,105,191.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,873,683.63 | 9,616,952.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,449,305.61 | 2,350,887.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,536,014.48 | 23,563,603.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 168,766,666.05 | 229,518,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,816,441.05 | 10,695,052.00 |
| 210302 | Түлш, халаалт | 141,783,615.00 | 201,672,140.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,166,610.00 | 17,150,908.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,929,100.00 | 8,767,136.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,196,900.00 | 2,060,986.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,614,000.00 | 2,614,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 995,000.00 | 770,950.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 5,600.00 | 244,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 778,700.00 | 800,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,338,900.00 | 2,276,400.00 |
| 2105 | Нормативт зардал | 47,474,380.00 | 72,329,172.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,690,600.00 | 1,760,472.00 |
| 210502 | Хоол, хүнс | 43,428,180.00 | 69,190,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,355,600.00 | 1,378,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 20,583,600.00 | 11,449,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,600,000.00 | 590,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,983,600.00 | 10,859,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,283,400.00 | 1,319,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,283,400.00 | 1,319,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,080,500.00 | 7,081,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,080,500.00 | 6,505,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 576,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,075,200.00 | 6,105,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,087,400.00 | 2,104,500.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,987,800.00 | 4,000,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 39,955,546.90 | 62,431,606.04 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 16,210,286.90 | 7,565,106.04 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,210,286.90 | 7,565,106.04 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 23,745,260.00 | 54,866,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,425,260.00 | 53,006,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,320,000.00 | 1,860,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **8,661,000.00** | **10,278,100.00** |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 8,661,000.00 | 10,278,100.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 8,661,000.00 | 10,278,100.00 |
| 223 | БУСАД ХӨРӨНГӨ | 8,661,000.00 | 10,278,100.00 |
| 223004 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,661,000.00 | 10,278,100.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | **(8,661,000.00)** | **(10,278,100.00)** |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII) | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 14 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 |
| 15 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,722,613,300.00** | **1,678,639,013.10** | **1,741,598,300.00** | **1,741,598,300.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,722,613,300.00** | **1,678,639,013.10** | **1,741,598,300.00** | **1,734,033,193.96** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,683,466,500.00** | **1,655,353,753.10** | **1,680,731,800.00** | **1,679,166,693.96** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,251,150,000.00 | 1,251,149,442.00 | 1,184,609,600.00 | 1,184,609,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 843,109,100.00 | 840,696,315.00 | 841,813,500.00 | 736,523,655.00 |
| 210102 | Нэмэгдэл | 315,313,900.00 | 317,649,601.00 | 277,405,300.00 | 378,073,249.00 |
| 210104 | Урамшуулал | 92,727,000.00 | 92,803,526.00 | 65,390,800.00 | 70,012,696.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 168,682,200.00 | 158,690,965.05 | 158,863,400.00 | 156,722,293.96 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 119,528,200.00 | 109,489,631.79 | 117,755,000.00 | 109,085,658.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,288,500.00 | 12,342,329.54 | 10,277,100.00 | 12,105,191.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,830,800.00 | 9,873,683.63 | 8,221,700.00 | 9,616,952.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,457,700.00 | 2,449,305.61 | 2,055,400.00 | 2,350,887.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,577,000.00 | 24,536,014.48 | 20,554,200.00 | 23,563,603.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 170,873,100.00 | 168,766,666.05 | 229,518,100.00 | 229,518,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,745,700.00 | 7,816,441.05 | 12,582,800.00 | 10,695,052.00 |
| 210302 | Түлш, халаалт | 131,994,000.00 | 141,783,615.00 | 186,393,900.00 | 201,672,140.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 26,133,400.00 | 19,166,610.00 | 30,541,400.00 | 17,150,908.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,618,200.00 | 9,618,200.00 | 9,057,100.00 | 9,057,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,196,900.00 | 1,196,900.00 | 1,230,700.00 | 1,482,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,614,000.00 | 2,614,000.00 | 2,614,000.00 | 2,614,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 995,000.00 | 995,000.00 | 1,023,100.00 | 770,950.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 1,081,600.00 | 1,081,600.00 | 1,112,100.00 | 1,112,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 778,700.00 | 778,700.00 | 800,800.00 | 800,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,952,000.00 | 2,952,000.00 | 2,276,400.00 | 2,276,400.00 |
| 2105 | Нормативт зардал | 62,912,900.00 | 47,474,380.00 | 71,170,600.00 | 71,170,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,690,600.00 | 2,690,600.00 | 601,900.00 | 601,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 58,866,700.00 | 43,428,180.00 | 69,190,700.00 | 69,190,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,355,600.00 | 1,355,600.00 | 1,378,000.00 | 1,378,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,983,600.00 | 11,983,600.00 | 19,005,500.00 | 19,005,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 0.00 | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,983,600.00 | 11,983,600.00 | 9,005,500.00 | 9,005,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,283,400.00 | 1,283,400.00 | 1,319,700.00 | 1,319,700.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,283,400.00 | 1,283,400.00 | 1,319,700.00 | 1,319,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,628,700.00 | 1,052,700.00 | 1,082,400.00 | 1,658,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,052,700.00 | 1,052,700.00 | 1,082,400.00 | 1,082,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - | - | 576,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,334,400.00 | 5,334,400.00 | 6,105,400.00 | 6,105,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 879,700.00 | 879,700.00 | 2,104,500.00 | 2,104,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,454,700.00 | 4,454,700.00 | 4,000,900.00 | 4,000,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 39,146,800.00 | 23,285,260.00 | 60,866,500.00 | 54,866,500.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 39146800.00 | 23285260.00 | 60,866,500.00 | 54,866,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 37,286,800.00 | 21,425,260.00 | 59,006,500.00 | 53,006,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,860,000.00 | 1,860,000.00 | 1,860,000.00 | 1,860,000.00 |
| **3** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **182,856,700.00** | **182,856,700.00** | **1,742,174,300.00** | **1,741,598,300.00** |
| 122 | Тусламж санхүүжилтийн орлого | 182,856,700.00 | 182,856,700.00 | 238,523,600.00 | 238,523,600.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 122005 | Төсвөөс санхүүжих | 182,856,700.00 | 182,856,700.00 | 238,523,600.00 | 238,523,600.00 |
| 123 | Татаас санхүүжилтийн орлого | 1,323,400,200.00 | 1,511,992,600.00 | 1,503,650,700.00 | 1,503,074,700.00 |
| 123001 | Тусгай санхүүжилтийн орлого | 1,323,400,200.00 | 1,511,992,600.00 | 1,503,650,700.00 | 1,503,074,700.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 0.0 | - | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 0.0 | - | 0.00 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 1 | 1 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 97 | 97 | 97 | 99 |
| 620001 | Удирдах ажилтан | 5 | 5 | 5 | 3 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 65 | 65 | 65 | 65 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 27 | 27 | 27 | 26 |
| 620004 | Гэрээт ажилтан | 0 | 0 | 0 | 5 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 1055 | 1055 | 1055 | 1055 |
| 630 | Ерөнхий боловсролын сургуульд суралцагч | 1055 | 1055 | 1055 | 1055 |
| 630001 | төрийн өмчит ЕБС | 1055 | 1055 | 1055 | 1055 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **9,013,408.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,013,408.00** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 9,013,408.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | |
| 2104 | Хангамж бараа материалын зардал | 578,136.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 578,136.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,158,572.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн зардал | 1,158,572.00 |
| 2106 | Эл хогшил, урсгал засварын зардал | 1,853,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,853,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж | 5,422,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,422,800.00 |

| | | |
|---|---|---|
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | **9,013,408.00** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | **9,013,408.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн эмчит бус этгээдээс авсан | 1,853,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 7,159,508.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Хархорин сумын Ерөнхий Боловсролын Орхон сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Чадварлаг аудит ХХК-ийн аудитор Б.Алтанцэцэг гүйцэтгэж, хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01-р сарын 25-ны өдрийн А/06 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Сурагчдыг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Зорилт-1 Танхимын сургалт удаан хугацаагаар зогссоны улмаас хүүхдийн дунд үүсэж болзошгүй түгшүүр, хөгжлийн ялгаатай байдал, сурлагаар хоцрох, сургууль завсардах зэрэг эрсдэлээс сэргийлэх хариу арга хэмжээ авч, тэгш бус байдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлэх үр дүнг тооцох.

Зорилт-2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, сургалтыг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулах

Зорилт-3 Багш бүр ээлжит хичээлийг чанартай бэлтгэж, хүүхэд бүрт тохирсон арга зүйг боловсруулан үр дүнтэй хэрэгжүүлж хоцрогдолгүй сургах

Зорилт -4 Багш, ажилтны ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх бүх талын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Зорилт-5 Сургууль бүр үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээг хамтын оролцоотой хийж, үр дүнг тооцон, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжихэд эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо түншлэлийг өргөжүүлэх
Зорилт-6 Боловсролын салбарын багш ажилтан, албан хаагчид ажлын арга барил ур чадвараа хөгжүүлж, ёс зүй манлайллаа эрхэмлэн ажиллах.
Зорилт-7 Сургалтын орчин, үйлчилгээг хүүхдэд ээлтэй байлгах
Зорилт-8 Ахлах ангийн суралцагчдын сонгон судлах хичээлийн төлөвлөлтийг сайжруулж, ахиц үр дүнг хүүхэд бүрээр тогтмол тооцох замаар элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хархорин сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын тушаалаар баталж мөрдөж байна.

Сумын Ерөнхий Боловсролын Сургуулийн бүтцэд дотоод хяналтын орон тооны алба байхгүй. Сургуулийн захирлын 2021 оны 10 сарын 30-ны А/32 тоот тушаалаар Дотоод хяналтын нэгжийг шинэчлэн 7 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллах журмыг мөн тушаалаар батлан хэрэгжүүлж ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Хархорин сумын Ерөнхий Боловсролын Орхон Сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 1910.1 сая төгрөгөөс 110 хувиар буюу 19.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд аймгийн ИТХурлын 2021 оны 11 сарын 24-ны өдрийн шийдвэрээр 1245.0 сая төгрөгийн барилга байгууламж, 981.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж,140.0 сая төгрөгийн газрыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж болон камер зэрэг тоног төхөөрөмжийг 26.6 сая төгрөгөөр худалдан авсан байна.

Бараа материалын хувьд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 1742.2 сая төгрөгийг улс,орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Санхүүжилт өмнөх оноос 1.2 хувиар өссөн байна. Энэ нь байр ашиглахтай холбоотой тогтмол зардал буюу халаах талбайн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой юм.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1741.6 сая төгрөгөөр санхүүжигдэн, 1741.6 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага тайлант онд 9.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авч хангамжийн бараа материалын санхүүжилтэнд 3.6 сая төгрөг,бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 5.4 сая төгрөгийг авч зарцуулсан байна .

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

**3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 149 мэдээлэл шилэн дансны сайтад байршуулахаас 129 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 3 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй, 17 мэдээллийг хугацаа хожимдуулж байршуулсан байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант хугацаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжинд томоохон шинэчлэл өөрчлөлт гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн */бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт /* нийцсэн/ байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8.6 сая төгрөгийн авлагыг нэмж бүртгэн залруулга хийх, төсвийн зардлын ангилал зөрчсөн 16.7 сая төгрөгийн зөрчилд 1 шаардлага өгсөн байна.Өмнөх аудитын хэрэгжилт 100 хувьтай байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитын тулгалтаар 149 мэдээлэл шилэн дансны сайтад байршуулахаас 17 мэдээллийг хугацаа хожимдуулж байршуулсан байна

**4.1 Залруулсан алдаа**

Байхгүй болно.

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Байхгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

2021 онд нийт 149 мэдээлэл шилэн дансны сайтад байршуулахаас 17 мэдээллийг хугацаа хожимдуулж байршуулсан байна

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хархорин сумын Ерөнхий Боловсролын, Орхон сургууль | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Б.АЛТАНЦЭЦЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР